

БАТЛАВ

ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН
ЗАХИРАЛ Г.ЦОГГЭРЭЛ

2021 оны 9 сарын 28 өдөр

УРАН БҮТЭЭЛ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот

№ 2021/0928

ҮУИТ-ыг төлөөлж нэг талаас ҮУИТ-ын “Монгол угсаатны билиг” шинэ уран бүтээлийн найруулагчийн ажлыг гүйцэтгэх Х.Энхбат /А тал гэх/, нөгөө талаас ҮУИТ-ын “Монгол угсаатны билиг” шинэ уран бүтээлийн видео бүтээлийг хүлээлгэн өгөхөөр “Гандаа медиа” ХХК-ийн захирал Б.Сараантуяа /Б тал гэнэ/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Гэрээний агуулга

Монгол өв соёл, үндэсний урлагийг өвлөн авч хайрлан хадгалах, уламжлан хөгжүүлэх зорилгоор Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулан Монгол угсаатны билиг, язгуур өвийн уран бүтээл, Үндэсний урлагийн их театрт “Монгол угсаатны билиг” тоглолтыг бүтээх төслийг хэрэгжүүлэхэд агуулга оршино.

Соёлын яамнаас 2021 онд зарласан төсөл хөтөлбөрт оролцож шалгарсан “Монгол угсаатны билиг” шинэ уран бүтээлийг хийж гүйцэтгэх, Үндэсний урлагийн их театрын захирлын Соёлын сайдтай хийсэн үр дүнгийн гэрээнд тусгагдсан шинэ уран бүтээл бүтээх тухай заалтыг баримтлан Захиалагч, Гүйцэтгэгч талуудын харилцаа, харилцан хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү гэрээгээр зохицуулна.

Нэг. А талын хүлээх үүрэг

- 1.1 Соёлын яамнаас шалгарсан ҮУИТ-ын “Монгол угсаатны билиг” шинэ уран бүтээлийн видео бүтээлийг хүлээлгэн өгөх боломжоор хангана.
- 1.2 Уран бүтээл хийх хөтөлбөрийн дагуух бүтээлийн жагсаалтыг Б талын гаргаж өгсний дагуу баталж шинэ уран бүтээлийн ажиллах нөхцөл бололцоогоор хангана.
- 1.3 Гүйцэтгэх ажлын график, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийг хянах, гүйцэтгэгчид санал зөвлөмж өгнө.

Хоёр. Б талын хүлээх үүрэг

- 2.1 Монгол улсын 21 аймагт тархан суурьшсан 11 ястны хувцас хэрэглэл, уламжлалт дуу, хөгжим, бүжиг, ардын язгуур урлагийн биет болон биет бус өвийг сурвалжлан судалгаа хийж сонгон видео сурвалж бүтээлийг хүлээлгэн өгнө.
- 2.2 ҮУИТ-ын “Монгол угсаатны билиг” уран бүтээлийн видео бүтээлийг чанартайгаар хүлээлгэн өгнө.
- 2.3 Хүлээлгэн өгөхдөө хугацаа харгалзахгүй бөгөөд захиалагчийн гаргасан саналыг хүлээж авч тусгана.
- 2.4 ҮУИТ-ын “Монгол угсаатны билиг” шинэ уран бүтээлийн ажлыг графикийн дагуу түүнтэй өөрийн хуваарийг уялдуулан ажлын багтайгаа нягт уялдаатай ажиллана.
- 2.5 “Монгол угсаатны билиг” төслийн орон нутаг болон бусад газар хийх бичлэг, судалгаа, бусад эх сурвалжаас зохиогчийн эрхийн маргаангүй хэрэглэх зардлыг гүйцэтгэгч тал өөрөө хариуцна.

Гурав. Хариуцлага

- 3.1 Гэрээний талууд гэрээнд заасан үүргээ харилцан бие биеэ хүндэтгэх үүднээс хариуцлагатай биелүүлнэ.
- 3.2 Гүйцэтгэгч талын хийсэн ажил нь чанарын болон бусад алдаатай бол 7 хоногийн дотор засч өгөх, зассан боловч шаардлага хангаагүй тохиолдолд Захиалагч тал ажлыг хүлээж авалгүй төлбөрийг буцааж авна.
- 3.3 Талууд гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,3 хүртэлх %-н алдангийг аль буруутай тал нь хүлээнэ.

Дөрөв. Нийлүүлэх хугацаа ба үнэ төлбөр

- 4.1. ҮУИТ-ын "Монгол угсаатны билиг" шинэ уран бүтээлийн видео бүтээлийг 2021 оны 12 сарын 5-ны дотор багтаан гүйцэтгэн хүлээлгэж өгнө.
- 4.2 ҮУИТ-ын "Монгол угсаатны билиг" шинэ уран бүтээлийн видео бүтээлийн хөлс нийт 20 000 000 төгрөг /хорин сая / байна
- 4.2. Гэрээний хугацаа 2019 оны 9 сарын 28-с 12 сарын 5-ыг дуустал хүчинтэй мөрдөгдөнө.

Тав. Төлбөр төлөх ажиллагаа

- 5.1. Захиалагч дээрх гүйцэтгэлийг гэрээ батлагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан гэрээнд заасан үнийн дүнгийн 80% болох 16 000 000 /арван зургаан сая/ төгрөгийг Худалдаа хөгжлийн банкны 499227735 тоот дансанд төлнө.
- 5.2. Захиалагч дээрх ажлыг бүрэн хүлээж авсан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан гэрээнд заасан үнийн дүнгийн 20% болох 4 000 000 /дөрвөн сая/ төгрөгийг Худалдаа хөгжлийн банкны 499227735 тоот дансанд төлнө.

Зургаа. Бусад нөхцлүүд

- 6.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний нөхцлийг өөрчлөх шаардлага гарвал талуудын харилцан зөвшилцсөний үндсэн дээр албан ёсоор бичгэн баримт үйлдэн баталгаажуулснаар өөрчилж болно. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.
- 6.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зөрчсөн тохиолдолд гэрээг нэг талын санаачлагаар цуцалж болно.
- 6.3 Талууд энэхүү гэрээнд тусгагдаагүй асуудлыг мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 6.4 Талууд зөвшилцөлд хүрч чадаагүй маргаантай асуудлыг хуулийн дагуу харьяа шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.5 Энэхүү гэрээг 2% үйлдэнэ.
- 6.6 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

А тал:

Х.Энхбат
Гарын үсэг: 

Холбоо барих: 88887507, 11323446



Б тал:

Б.Сарантуяа
Гарын үсэг: 

Холбоо барих: 99108867